



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

2025.02.25 № 81
танай _____-ны № _____-т

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЭНХТУСДЭМ
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА О.ОДМАНДАХ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Энхтусдэм" өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт...3...хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



D:/2025/Alban toot.doc

422503078



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЭНХТУСДЭМ ЗГБХН ӨРХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
О.ОДМАНДАХ ТАНАА

2025.02.25 № 28
танай _____-ны № _____-т

Татгалзсан санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Энхтусдэм ЗГБХН өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга тайлангуудад аудит хийхээр байсан.

Бидний үзэж байгаагаар Татгалзсан санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласны дагуу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулга тайлангуудад дүгнэлт өгөхгүй. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Татгалзсан санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дүгнэлт өгөхөөс татгалзсан үндэслэлүүд:

1. Санхүүгийн тайлангийн аудит хийх тухай 2025.01.08-ны өдрийн 25 дугаартай албан бичиг хүргүүлсэн боловч санхүүгийн тайлангийн аудит хийлгэхгүй тухай тайлбарыг 2025.01.20-ны өдрийн 8 дугаартай албан бичгээр ирүүлж, аудитад шаардлагатай тайлан баримт материалыг ирүүлээгүй, хуулийн хугацаанд санхүүгийн тайланд аудит хийлгээгүй
2. MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”: 6 төрийн аудитын зарчим, 6.4.3.1.3 Санал дүгнэлт, 6.4.3.1.3.3 Татгалзсан–Аудитор тодорхой бус байдал, хамрах хүрээний хязгаарлалтаас шалтгаалан хангалттай ба зохистой нотлох зүйл олж авах боломжгүй бөгөөд тэдгээр нь материаллаг болоод өргөн тархсан үед
3. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/66 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Санхүүгийн аудитын зарчим” стандартын 64-т Аудитор нь дараах гурван төрлийн өөрчлөлттэй санал дүгнэлтийг гаргаж болно: ... татгалзсан санал дүгнэлт – тодорхойгүй байдал болон хамрах хүрээний хязгаарлалтаас

422562100

шалтгаалж аудитор хангалтай, зохистой аудитын нотолгоог олж авах боломжгүй, энэ нь материаллаг бөгөөд өргөн тархсан үед

Эдгээр зөрчлүүд нь Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2024.07.08-ний өдрийн А/320 дугаар тушаалаар баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм”-ийн 6.6-д “төв нь өөрийн санхүүгийн үйл ажиллагаанд аудитын дүгнэлт, зөвлөмж гаргуулсан байна” гэснийг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА

